- УБЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/67 дугаар тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан.

- УБЕГ-ын даргын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн "Гэрээт ажилтны хязгаарыг шинэчлэх батлах тухай" Б/407 дугаар тушаалаар гэрээт ажилтны тоог бууруулсан.

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/45 дугаар тушаалыг үндэслэн УБЕГ-ын даргын 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн "Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/157 дугаар тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг УБЕГ-ын Хяналт шинжилгээний газар хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Хууль зүй дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/87 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Тус баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/3 дугаар

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,376.6 мянган төгрөг буюу 4.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	19,400.2	0.0	(19,400.2)
Авлага	426.8	16,100.2	15,673.4
Бараа материал	55,434.5	59,374.6	3,940.1
Үндсэн хөрөнгө	2,210,404.4	2,190,061.0	(20,343.4)
Хуримтлагдсан элэгдэл	(365,885.4)	(422,131.9)	(56,246.5)
Нийт хөрөнгө	1,919,780.5	1,843,403.9	(76,376.6)
Өр төлбөр	0.0	19,851.4	19,851.4
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн	1,919,780.5	1,823,552.5	(96,228.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн	1,919,780.5	1,843,403.9	(76,376.6)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 0.0 төгрөг.

Авлагын дансны үлдэгдэл 16,100.2 мянган төгрөг болж өмнөх оноос 15,673.4 мянган төгрөгөөр өссөн бөгөөд энэ нь Ахмадын сангийн дансны үлдэгдлийн татан төвлөрүүлэлттэй холбоотой үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,374.6 мянган төгрөг болж өмнөх оноос 3,940.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 25,968.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, УБЕГ-аас 16,800.9 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 38,828.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,767,929.1 мянган төгрөг болж 76,589.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд аймгийн ИТХ-ын 2025 оны 7/40 дугаар тогтоолоор 470.0 мянган төгрөгийн тавилга, ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 333 дугаар тогтоол, 2026 оны А1/75 тоот албан бичгээр 14,642.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүтгэсэн, ТӨБЗГ-ын 2025 оны 864 дүгээр тогтоолоор тус хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 18 нэр төрлийн 24,918.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан, мөн 816 дугаар тогтоолын дагуу 12 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд 10,536.8 мянган төгрөгийн шинэчилсэн үнэ тогтоож дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны эцэст 19,851.4 мянган төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд 17,288.4 мянган төгрөг нь ажиллагчидтай холбоотой цалингийн өр, 2,563.0 мянган төгрөг нь бичиг хэргийн зардалтай холбоотой өглөг байна.

Ажиллагчидтай холбоотой цалингийн өр нь 2025 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллын өр бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ажилчдын гарт олгогдох үр дүнгийн урамшууллын гүйлгээ банк хоорондын гүйлгээгээр шилжиж амжаагүйтэй холбоотой үүссэн байна. Харин бичиг хэргийн зардлын өр нь 2025 оны 11 болон 12 дугаар саруудад тус зардлын зарцуулах эрхийг нээж өгөөгүй, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр зарцуулах эрхийг нээж өгсөний дагуу гүйлгээ хийсэн боловч банк хоорондын гүйлгээ хийгдэж амжаагүйтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг буцаан татсан байна.

Бичиг хэргийн зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 584.7 мянган төгрөгөөр илүү, батлагдсан төсвийн 55.6%-ийг зарцуулсан, 12,399.5 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,823,552.5 мянган төгрөг болж 96,227.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous санхүүгийн программыг 2017 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд санхүүгийн тайланд бүртгэлгүй байна. Программ хангамжтай холбоотойгоор тайлант онд зардал гараагүй.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,541,810.1 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 97,306.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,639,116.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 4 удаа тодотгон 31,783.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,670,899.8 мянган төгрөгөөр баталсан нь ажилчдын цалин хөлс нэмэгдсэн, мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1,670,899.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,648,699.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,619,973.4 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 7,476.9 мянган төгрөг зарцуулаагүй, хангамж бараа материалын зарим зардлын зарцуулах эрхийг 11 ба 12 саруудад нээж өгөөгүйгээс 12,399.5 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт (хувь)
1	70406 Улсын бүртгэл, мэдээлэл	1,670,899.8	1,619,973.4	50,926,449.9	97.0
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,670,899.8	1,619,973.4	50,926,449.9	97.0
1.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	0.0	0.0	0.0	0.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Бүтэц, орон тооны гүйцэтгэл

Аймгуудын улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны Б/424 тоот тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны "Улсын бүртгэлийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай" А/176 дугаар тушаалыг үндэслэн үндсэн 36 орон тоотой, дарга, хяналтын улсын байцаагч, ахлах нягтлан бодогч, мэдээллийн технологийн ажилтан, архивч, бичиг хэргийн эрхлэгч, нярав, иргэний улсын бүртгэлийн тасаг, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг гэсэн бүтэцтэйгээр, нэмж 4 гэрээт ажилтантай, нийт 40 орон тоотой байхаар баталж өгсөн байна.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025 оны "Цалин шинэчлэн тогтоох тухай" А/01 дугаар тушаалаар ТЗ-ны албан хаагч 29, ТҮ-ний албан хаагч 4, гэрээт албан хаагч-4, нийт 37 орон тоотой ажиллахаар төлөвлөсөн байна. /1 албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй/

УБЕГ-ын даргаас ирсэн тушаал шийдвэрийн дагуу ажилтанг томилж, чөлөөлдөг байна.

УБЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/67 дугаар тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталж үндсэн 35 орон тоотой байхаар тогтоож өгсөн байна.

2025 оны 11 дүгээр сараас Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/45 дугаар тушаалыг үндэслэн УБЕГ-ын даргын "Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/157 дугаар тушаалаар үндсэн 36 орон тоотой, гэрээт 2, нийт 38 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Орон тооны цомхотголыг УБЕГ-аас ирсэн тушаал шийдвэрийн дагуу 2025 оны 11 дүгээр сард хийж ТЗ-гүйцэтгэх албан тушаалаас 1, ТҮ-гэрээт албан тушаалаас 1, нийт орон тоог 2 буюу 5.0 хувиар бууруулан шийдвэрлэсэн байна. Гүйцэтгэх албан тушаалын хувьд 2024 онд тэтгэвэрт гарсан орон тоон дээр

томилгоо хийгээгүй байсан орон тоо, гэрээт албан хаагчийн хувьд дохиолол хамгаалалтын албатай гэрээ байгуулан хамгаалалтыг гүйцэтгүүлэх болсонтой холбогдуулан харуул хамгаалалтын ажилтны орон тоог 1-ээр бууруулсан байна. Цомхотгосон орон тоотой холбоотойгоор 2025 онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 34,641.6 мянган төгрөг хэмнэсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2026 оны "Цалин шинэчлэн тогтоох тухай" А/01 дугаар тушаалаар ТЗ албан хаагч -30, ТҮ албан хаагч 5, үндсэн 35 орон тоотой, гэрээт албан хаагч 2, нийт 37 орон тоотой ажиллахаар төлөвлөн баталсан байна. Үндсэн 35 орон тооноос 2 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй, 1 ажилтан ЖБА-ны амралттай байна.

Унаа, хоолны хөнгөлөлт (2100103)-ийн зардал

УБЕГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/164 тоот тушаалаар хоолны хөнгөлөлтөнд нэг өдрийн 25.0 мянган төгрөгийг ажилтанд тооцож олгодог байна.

Тайлант онд хоолны хөнгөлөлтийн зардалд 250,524.1 мянган төгрөг төлөвлөгдөж 100 хувь зарцуулсан байна. Ажилчдад унааны хөнгөлөлт олгодоггүй.

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал

Тус зардалд 1 арга хэмжээ, нийт 1,195.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 500.0 мянган төгрөг зарцуулсан байна. 2025 оны 05 дугаар сард Баянхонгор аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн даргын "Нэгдсэн сургалт зохион байгуулах тухай" А/05 дугаар тушаалаар хэлтсийн албан хаагчид, түүний гэр бүл, ахмад ажилчдаа оролцуулан Баянхонгор аймагт зохион байгуулсан байна.

Өөрийн орлого буюу төвлөрүүлэх шилжүүлэг

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн "Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай" 230 дугаар тогтоолын дагуу иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх замаар орлого бүрдүүлсэн байна.

2025 онд 200,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласан ба гүйцэтгэлээр 283,217.8 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 141.6 хувьтай биелүүлсэн байна. Иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлж 79,245.1 мянган төгрөгийн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээнээс 203,972.7 мянган төгрөгийн орлого олж, тус орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Газар эзэмших, ашиглах эрхийн байдал

Тус байгууллагад 1762 м2 талбай бүхий эзэмших эрхтэй газрыг 2022 онд 3 жилийн хугацаатай эзэмшүүлж, гэрчилгээг шинэчлэн олгосон байна. Гэрээний хугацаа 2025.06.23-ны өдөр дууссан ба 2026.02.05-ны өдөр газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлтээ egazar.gov.mn цахим сайтад илгээсэн байна.

Тус газар нь санхүүгийн бүртгэл тайланд 572 м2 буюу тоо хэмжээний хувьд зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Байгууллагын оноосон нэр, түүний хэрэглээ

Улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын оноосон нэр нь "Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс" нэрээр, албан бланкны толгойд "Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс" нэрээр зөрүүтэй илэрхийлэгдсэн байсныг аудитын явцад залруулж оноосон нэрийг зөв болгон өөрчилсөн болно.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс 16,890.5 мянган төгрөг, орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуулийн санхүүжилт 7,160.0 мянган төгрөг, шагналын 1,900.0 мянган төгрөг, киоск машины засвар үйлчилгээний зардал 1,800.0 мянган төгрөг, нийт 27,750.5 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрснийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 87,032.7 мянга, гэрэл цахилгааны зардалд 5,029.9 мянга, цэвэр бохир усны зардалд 3,688.2 мянган төгрөг батлагдаж "Эх бүрдэн" ХХК-тай дулаанаар хангах гэрээ, "Хонгор жаст" ХХК-тай шатахууны гэрээ, "Чандмань-Баянхонгор" ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээ, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-тай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 11/57 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,670,899.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,709.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 10,860.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн тайлангийн түвшинд газар эзэмших, ашиглах эрхийн байдалтай холбоотой 1 эрсдэлийг нэмж тодорхойлон, холбогдох горим сорилыг гүйцэтгэв.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 92.2 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 51 гүйлгээний 2,345,036.7 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг 100 хувь мэдээлсэн байна.

Шилэн дансны дэлгэрэнгүй мэдээлэл буюу байгууллагын ерөнхий мэдээлэл дэх мэдээлэл, үнэн зөв, бүрэн гүйцэт байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитаар 29,499.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 13/213 дугаартай албан бичиг, 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 13/496 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	29,499.9	2	29,499.9	100%
Нийт дүн	2	29,499.9	2	29,499.9	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн анхаарах асуудлын дагуу нягтлан бодогчид балансын урамшуулал олгосон эсэхийг шалгахад 2025 онд урамшуулал олгоогүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 зөрчил илэрсэн тул албан шаардлага хүргүүлэв.

Тус илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинд нөлөө үзүүлэхгүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар нь үндсэн хөрөнгийн бүртгэлд 572 мкв-аар, газар эзэмших эрхийн гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 1762 мкв-аар бүртгэлтэй буюу 1190 мкв-аар зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө 17.12-т "Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын хэмжээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган, зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар нь үндсэн хөрөнгийн бүртгэлд 572 мкв-аар, газар эзэмших эрхийн гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 1762 мкв-аар бүртгэлтэй буюу 1190 мкв-аар зөрүүтэй бүртгэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.	1	0	-	-	1	0	-	-
Дүн	1	0	-	-	1	0	-	-

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 23/А0571370/БНА-2026/1151

Номгон

НА-СТА-ТШЗ

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар нь үндсэн хөрөнгийн бүртгэлд 572 мкв талбайтай бүртгэгдсэн байхад газрын эзэмших гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 1762 мкв-аар бүртгэлтэй буюу 1190 мкв-аар зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө 17.12-т "Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж, нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган, зөрчлийг арилгаж, нотлох баримтыг 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

6426090072

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал, нягтлан бодогч Г.Бат-Очир нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР

Д.ОЮУН-ЭРДЭНЭ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

